



**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН
2020 ОНЫ ГУРАВДУГААР
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	2
1.1 ХЗХ-ны салбарын ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	4
1.4 Хууль тогтоомжийн өөрчлөлт.....	5
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	6
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	6
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	7
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	7
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	8
2.2.3 “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-т хамрагдсан, уг хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	8
2.2.4 “Ногоон алт” төслийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	9
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	10
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	10
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	11
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	11
3.4 Зээлийн чанарын талаар.....	12
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР	13
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	13
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	14
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....	14
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....	15
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	15
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	16
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА	16
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	16
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	17
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	17
5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-дын талаар.....	18
5.5 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-дын талаар.....	18
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР	18
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	18
6.2 Улаанбаатар хотын ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	19
6.3 Орон нутгийн ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	20
6.4 “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	21
ДОЛОО.ДҮГНЭЛТ	22

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2020 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2020.10.30


Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 ХЗХ-ны салбарын ерөнхий мэдээлэл

2020 оны 3 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 248 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 ХЗХ буюу 8.5 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 39.5 хувь буюу 98 ХЗХ хөдөө орон нутагт, 60.5 хувь буюу 150 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулсан байна.

График 1: ХЗХ-дын тоо, хот хөдөөгөөр, сүүлийн 5 жилийн байдлаар



Тайлант улиралд Хорооны хуралдаанаар шинээр 1 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 12 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 7 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 9 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Мөн 2020 оны 3 дугаар улиралд 4 ХЗХ-ны сонгуульт гишүүд, гүйцэтгэх албаны өөрчлөлт, 1 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг

холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2016	2017	2018	2019	2020.Ш
Шинээр олгосон	34	17 /1/	18	17	11
Хүчингүй болгосон	7	8	29	35	24
Түдгэлзүүлсэн	2	21	19	10	22
Сэргээсэн	-	4	7	1	6
ТЗ-ийн хугацаа сунгасан	48	54	100	52	42
ХЗХ-дын тоо	280	290	279	261	248

Зураг 1: ХЗХ-дын эрхэлж буй үйл ажиллагаа




1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2020 оны 3 дугаар улирлын байдлаар 248 ХЗХ 61 салбар, 805 ажилтан, 73,183 гишүүн /73,044 иргэн, 139 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын 9 дүүрэгт 150 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 ХЗХ буюу 11.2 хувиар буурсан үзүүлэлттэй байх бөгөөд Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Зураг 2: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



Хөдөө орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 98 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 ХЗХ буюу 3.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Баян-Өлгий, Орхон, Увс, Говь-Алтай, Ховд аймгуудад ХЗХ-д ихээр төвлөрсөн байгаа бол Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 3: ХЗХ-дын тархалт



Тайлант улирлын байдлаар нийт 7 ХЗХ 61 салбартайгаар үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд салбарын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 салбар буюу 12.9 хувиар нэмэгдсэн байна.

Салбарын тархалтын хувьд 4 ХЗХ-ны 7 салбар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж, 3 ХЗХ-ны 54 салбар хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2020 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3062 гишүүн буюу 4.4 хувиар нэмэгдэж 73,183-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 52.4 хувь буюу 38,384 эмэгтэй гишүүн байна.

Зураг 4: ХЗХ-ны гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 61.4 хувь буюу 44,902 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын гишүүд байгаа бол 38.6 хувь буюу 28,281 нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын гишүүд байна.

График 3: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт, хот, хөдөөгөөр, сүүлийн 5 жилийн байдлаар




2017-2020 онуудад ХЗХ-дын тоо буурсан ч гишүүдийн тоо тогтмол өссөн байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын нийт гишүүдийн 11.0 хувь буюу 8,069 гишүүн “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан 83 ХЗХ-ны гишүүд байна.

Мөн тайлант улиралд “Ногоон алт” төслийн хүрээнд байгуулагдсан 31 ХЗХ 9,273 гишүүнтэй үйл ажиллагаа явуулсан байна.

Нийт 248 ХЗХ-ны 48.0 хувь буюу 119 ХЗХ 20-100 гишүүнтэй, 41.9 хувь буюу 104 ХЗХ 101-500 гишүүнтэй, 6.9 хувь буюу 17 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 3.12 хувь буюу 8 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

График 4: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 8 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 46.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүд	Эзлэх хувь
20-100 гишүүнтэй	119	6,709	9.2%
101-500 гишүүнтэй	104	21,357	29.2%
501-1,000 гишүүнтэй	17	11,155	15.2%
1,001-ээс дээш гишүүнтэй	8	33,962	46.4%
Нийт	248	73,183	100.0%

1.4 Хууль тогтоомжийн өөрчлөлт

- Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж хүчингүй болгох шаардлагатай Хорооны 2012 оны 136 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос үзүүлэх тогтворжилтын үйлчилгээний журам”-ыг Хорооны 2020 оны 353 дугаар тогтоолоор хүчингүй болгосон.

- Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс эдийн засгийн идэвхжил саарч, иргэд, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэний улмаас санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалах зорилгоор Хорооны дарга, Сангийн сайдын 2020 оны 122/58 дугаар тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д өөрчлөлт оруулж 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд мөрдүүлэхээр шийдвэрлэсэн. Түр журмын үйлчлэх хугацаа дуусахад эдийн засгийн нөхцөл байдал сайжраагүй тул дахин өөрчлөлт оруулж Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаанд буюу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгахаар Хорооны 2020 оны 854 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн.

- Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах, тогтворжилтын сангийн үйлчилгээг эхлүүлэхтэй холбоотой эрх зүйн орчныг бий болгох, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангахтай холбоотойгоор хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг 3 сарын хугацаанд хүлээж авахгүй байх шийдвэрийг Хорооны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар, 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг

дуустал хүлээж авахгүй байх шийдвэрийг Хорооны 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар тус тус шийдвэрлэсэн.

- “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-г тусгагдсаны дагуу эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх чиглэлээр холбогдох бэлтгэлийг ханган ажиллаж байна. ХЗХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд зайны хяналт, газар дээрх шалгалт хийж, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилго бүхий “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх журам”-ын төслийг боловсруулсан ба төсөлд санал авахаар Хорооны цахим хуудаст байршуулж, цахим хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2020 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны салбарын нийт хөрөнгө 234,281,258.14 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.3 хувь буюу 15,924,364.84 мянган төгрөгөөр өсөж банкны салбарын 0.7 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 5.2 хувь буюу 8,414,213.87 мянган төгрөг, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж

6.0 хувь буюу 9,213,753.00 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Салбарын нийт орлого 5.3 хувь буюу 1,990,282.21 мянган төгрөг, нийт зарлага 3.1 хувь буюу 957,095.12 мянган төгрөгөөр тус тус өссөнөөр нийт цэвэр орлого 16.1 хувь буюу 1,033,187.10 мянган төгрөгөөр нэмэгдэж 7,439,454.50 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 4: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2019 оны III улирал	2020 оны III улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	218,356,893.30	234,281,258.14	15,924,364.84	7.3%
Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.7%		
Нийт зээл	162,765,904.40	171,180,118.27	8,414,213.87	5.2%
Банкны салбарт эзлэх хувь	0.9%	1.0%		
Нийт чанаргүй зээл	6,186,819.40	7,277,665.30	1,090,845.90	17.6%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.8%	4.3%	0.5%	11.8%
Банкны салбарт эзлэх хувь	0.3%	0.4%		
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	154,420,879.30	163,634,632.30	9,213,753.00	6.0%
Банкны салбарт эзлэх хувь	1.2%	1.0%		
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	17,531,534.90	18,283,275.63	751,740.73	4.3%
Нийт хоршоологчдын өмч	22,161,460.50	29,035,356.53	6,873,896.03	31.0%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	10,366,668.50	9,197,368.67	-1,169,299.83	-11.3%
Нийт орлого	37,316,753.00	39,307,035.21	1,990,282.21	5.3%
Нийт зарлага	30,910,485.60	31,867,580.72	957,095.12	3.1%
Цэвэр орлого, алдагдал	6,406,267.40	7,439,454.50	1,033,187.10	16.1%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 150 ХЗХ-ны нийт хөрөнгө 198,682,135.41 мянган төгрөг нь салбарын 84.8 хувь, нийт зээл 141,873,990.73 мянган төгрөг нь салбарын 82.9 хувь, нийт хадгаламж 141,020,194.33 мянган төгрөг нь салбарын 86.2 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.1 хувь буюу 1,071,248.16 мянган төгрөгөөр нэмэгдэж 6,675,200.56

мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 4.7 хувийг бүрдүүлж байна. Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл өмнөх оны мөн үеэс 12.7 хувь буюу 1,305,328.03 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 3.2 хувь буюу 996,079.18 мянган төгрөгөөр, нийт зарлага 0.6 хувь буюу 150,844.00 мянган төгрөгөөр тус тус өссөнөөр цэвэр орлого 17.5 хувь буюу 845,235.18 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2019 оны III улирал	2020 оны III улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	189,887,212.70	198,682,135.41	8,794,922.71	4.6%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	87.0%	84.8%	-2.2%	-2.5%
Нийт зээл	138,965,264.80	141,873,990.73	2,908,725.93	2.1%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	85.4%	82.9%	-2.5%	-2.9%

Нийт чанаргүй зээл	5,603,952.40	6,675,200.56	1,071,248.16	19.1%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	90.6%	91.7%	1.1%	1.3%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.0%	4.7%	0.7%	16.7%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	137,374,769.10	141,020,194.33	3,645,425.23	2.7%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	89.0%	86.2%	-2.8%	-3.1%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	12,562,404.70	13,253,773.79	691,369.09	5.5%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	71.7%	72.5%	0.8%	1.2%
Нийт хоршоологчдын өмч	17,557,689.00	23,504,751.10	5,947,062.10	33.9%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	79.2%	81.0%	1.7%	2.2%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	10,265,610.20	8,960,282.17	-1,305,328.03	-12.7%
Нийт орлого	31,141,622.50	32,137,701.68	996,079.18	3.2%
Нийт зарлага	26,300,828.00	26,451,672.00	150,844.00	0.6%
Цэвэр орлого, алдагдал	4,840,794.50	5,686,029.68	845,235.18	17.5%

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 98 ХЗХ-ны нийт хөрөнгө 35,599,122.73 мянган төгрөг нь салбарын 15.2 хувь, нийт зээлийн үлдэгдэл 29,306,127.54 мянган төгрөг нь салбарын 17.1 хувь, нийт хадгаламж 22,614,437.97 мянган төгрөг нь салбарын 13.8 хувийг тус тус эзэлж байна. Нийт

орлого өмнөх оны мөн үеэс 16.1 хувь буюу 994,203.03 мянган төгрөг, нийт зарлага 17.5 хувь буюу 806,251.12 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, цэвэр орлого 12.0 хувь буюу 187,952.01 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,753,424.81 мянган төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 6: Хөдөө орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2019 оны III улирал	2020 оны III улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	28,469,680.70	35,599,122.73	7,129,442.03	25.0%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	13.0%	15.2%	2.2%	16.5%
Нийт зээл	23,800,639.60	29,306,127.54	5,505,487.94	23.1%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	14.6%	17.1%	2.5%	17.1%
Нийт чанаргүй зээл	582,867.00	602,464.74	19,597.74	3.4%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	9.4%	8.3%	-1.1%	-12.1%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	2.4%	2.1%	-0.4%	-16.1%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	17,046,110.20	22,614,437.97	5,568,327.77	32.7%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	11.0%	13.8%	2.8%	25.2%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	4,969,130.20	5,029,501.84	60,371.64	1.2%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	28.3%	27.5%	-0.8%	-2.9%
Нийт хоршоологчдын өмч	4,603,771.60	5,530,605.43	926,833.83	20.1%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	20.8%	19.0%	-1.7%	-8.3%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	101,058.40	237,086.50	136,028.10	134.6%
Нийт орлого	6,175,130.50	7,169,333.53	994,203.03	16.1%
Нийт зарлага	4,609,657.60	5,415,908.72	806,251.12	17.5%
Цэвэр орлого, алдагдал	1,565,472.90	1,753,424.81	187,951.91	12.0%

2.2.3 “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-т хамрагдсан, уг хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Тайлант улиралд төслийн хүрээнд байгуулагдсан 83 ХЗХ үйл ажиллагаа явуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 ХЗХ буюу 15.3 хувь буурсан байна. Төслийн ХЗХ-дын нийт хөрөнгө 8,181,088.23 мянган төгрөг нь салбарын 3.5 хувь, нийт зээл 6,644,824.32

мянган төгрөг нь салбарын 3.9 хувь, нийт хадгаламж 2,030,408.56 мянган төгрөг нь салбарын 1.2 хувийг тус тус эзэлж байна. Тайлант улиралд банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 4,519,314.38 мянган төгрөгт хүрснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.7

хувь буюу 1,819,414.02 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 60.1 хувь буюу 1,676,933.08 мянган төгрөг, нийт зарлага 20.2 хувь буюу 282,322.65 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Тайлант улиралд цэвэр орлого 527.47 мянган төгрөгт

хүрснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99.9 хувь буюу 1,394,610.43 төгрөгөөр буурсан байна. Төсөлд хамрагдсан ХЗХ-д санхүүжилтийг санд төвлөрүүлснээр орлого олох эх үүсвэр буурч ашиг алдагдалд нөлөөлсөн байна.

Хүснэгт 7: Нийслэлийн хөтөлбөрийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2019 оны III улирал	2020 оны III улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
Нийт хөрөнгө	10,250,675.60	8,181,088.23	-2,069,587.37	-20.2%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	4.7%	3.5%	-1.2%	-25.4%
Нийт зээл	8,559,625.30	6,644,824.32	-1,914,800.98	-22.4%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	5.3%	3.9%	-1.4%	-25.8%
Нийт чанаргүй зээл	312,627.50	299,647.52	-12,979.98	-4.2%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	5.1%	4.1%	-1.0%	-18.9%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.7%	4.5%	0.9%	23.5%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	2,145,568.50	2,030,408.56	-115,159.94	-5.4%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	1.4%	1.2%	-0.2%	-13.6%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	831,020.60	746,697.20	-84,323.40	-10.1%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	4.7%	4.1%	-0.6%	-13.5%
Нийт хоршоологчдын өмч	356,151.60	424,751.24	68,599.64	19.3%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	1.6%	1.5%	-0.1%	-6.7%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	6,338,728.40	4,519,314.38	-1,819,414.02	-28.7%
Нийт орлого	2,790,761.10	1,113,828.02	-1,676,933.08	-60.1%
Нийт зарлага	1,395,623.20	1,113,300.55	-282,322.65	-20.2%
Цэвэр орлого, алдагдал	1,395,137.90	527.47	-1,394,610.43	-99.96%

2.2.4 “Ногоон алт” төслийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Төсөл хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан 31 ХЗХ-ны гишүүдийн тоо 9,273 буюу салбарын нийт гишүүдийн 12.7 хувийг эзэлж байна. Тус ХЗХ-дын нийт хөрөнгө 7,769,013.72 мянган төгрөг нь салбарын 3.3 хувь, нийт зээл 6,559,185.34 мянган төгрөг нь салбарын 3.8 хувь, нийт хадгаламж 5,132,809.96 мянган төгрөг нь салбарын 3.1 хувийг тус тус эзэлж байна. Тайлант улиралд банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 74,699.96 мянган төгрөг байгаа бол нийт орлого 1,448,072.34 мянган төгрөг, нийт зарлага 1,125,852.93 мянган төгрөг, цэвэр орлого 322,219.41 мянган төгрөг байна.

Хүснэгт 8: “Ногоон алт” төслийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2020 оны III улирал
Нийт хөрөнгө	7,769,013.72
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	3.3%
Нийт зээл	6,559,185.34
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	3.8%
Нийт чанаргүй зээл	160,845.16
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	2.2%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	2.5%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	5,132,809.96
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	3.1%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	1,104,786.83
ХЗХ-ны нийт хувь хөрөнгөд эзлэх хувь	6.0%
Нийт хоршоологчдын өмч	682,324.99
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	2.3%
Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл	74,699.96
Нийт орлого	1,448,072.34
Нийт зарлага	1,125,852.93
Цэвэр орлого, алдагдал	322,219.41

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2019 оны III улирал		2020 оны III улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгө	213,621,128.50	97.8%	230,140,166.47	98.2%	16,519,037.97	7.7%
Мөнгөн хөрөнгө	46,383,348.60	21.2%	52,971,378.09	22.6%	6,588,029.49	14.2%
Бэлэн мөнгө	2,779,889.80	1.3%	6,194,473.88	2.6%	3,414,584.08	122.8%
Банкинд байршуулсан харилцах	27,104,277.10	12.4%	29,037,888.50	12.4%	1,933,611.40	7.1%
Банкинд байршуулсан хадгаламж	16,499,181.70	7.6%	17,739,015.71	7.6%	1,239,834.01	7.5%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.0%	100,000.00	0.0%	100,000.00	
Арилжааны үнэт цаас	0.00	0.0%	100,000.00	0.0%	100,000.00	
Зээл /цэврээр/	158,215,954.40	72.5%	166,264,967.94	71.0%	8,049,013.54	5.1%
Нийт зээл	162,765,904.40	74.5%	171,180,118.27	73.1%	8,414,213.87	5.2%
Хэвийн зээл	148,322,882.40	67.9%	159,055,152.16	67.9%	10,732,269.76	7.2%
Хугацаа хэтэрсэн зээл	8,256,202.50	3.8%	4,847,300.82	2.1%	-3,408,901.68	-41.3%
Чанаргүй зээл	6,186,819.40	2.8%	7,277,665.30	3.1%	1,090,845.90	17.6%
(Зээлийн эрсдэлийн сан)	4,549,949.90	2.1%	4,915,150.33	2.1%	365,200.43	8.0%
Авлага	7,390,520.30	3.4%	8,567,927.72	3.7%	1,177,407.42	15.9%
Байгууллага, хүмүүсээс авах авлага	1,090,766.00	0.5%	1,433,238.04	0.6%	342,472.04	31.4%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	6,299,754.30	2.9%	7,134,689.68	3.0%	834,935.38	13.3%
Бусад эргэлтийн хөрөнгө	756,053.90	0.3%	1,043,040.42	0.4%	286,986.52	38.0%
Өмчлөх бусад хөрөнгө /цэвр/	875,251.30	0.4%	1,192,852.30	0.5%	317,601.00	36.3%
Өмчлөх бусад хөрөнгө	1,047,624.40	0.5%	1,198,930.65	0.5%	151,306.25	14.4%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	172,373.10	0.1%	6,078.35	0.0%	-166,294.75	-96.5%
Эргэлтийн бус хөрөнгө	4,735,764.80	2.2%	4,141,091.67	1.8%	-594,673.13	-12.6%
Үндсэн хөрөнгө /цэвр/	4,612,819.40	2.1%	3,914,112.94	1.7%	-698,706.46	-15.1%
Үндсэн хөрөнгө	5,875,628.10	2.7%	5,476,988.54	2.3%	-398,639.56	-6.8%
(Хуримтлагдсан элэгдэл)	1,262,808.70	0.6%	1,562,875.59	0.7%	300,066.89	23.8%
Биет бус хөрөнгө	107,925.50	0.0%	211,958.73	0.1%	104,033.23	96.4%
Биет бус хөрөнгө	130,795.80	0.1%	298,542.58	0.1%	167,746.78	128.3%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	22,870.30	0.0%	86,583.85	0.0%	63,713.55	278.6%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,020.00	0.0%	15,020.00	0.0%	0.00	0.0%
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,020.00	0.0%	15,020.00	0.0%	0.00	0.0%
Хөрөнгийн дүн	218,356,893.30	100%	234,281,258.14	100%	15,924,364.84	7.3%

Зураг 5: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/



2020 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны салбарын нийт хөрөнгө 234,281,258.14 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.3 хувь буюу 15,924,364.84 мянган төгрөгөөр өссөн байна. Салбарын нийт хөрөнгийн 98.2 хувийг эргэлтийн хөрөнгө, 1.8 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 22.6 хувийг, цэвр зээл 71.0 хувийг тус тус эзэлж байна.


Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5.2 хувь буюу 8,414,213.87 мянган төгрөгөөр өсөж 171,180,118.27 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 4,915,150.33 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 166,264,967.94 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна. Харин хэвийн бус зээлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.3 хувь буюу 3,408,901.68 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны салбарын нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулан харвал 2017-2020 онуудад ХЗХ-дын тоо буурсан ч хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 3 ХЗХ-ны нийт хөрөнгө 143,217,906.99 мянган төгрөг нь салбарын

График 7: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



нийт хөрөнгийн 61.1 хувийг, гишүүдийн тоо 22,088 байгаа нь нийт гишүүдийн 30.2 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүдийн тоо		
			Дүн	Хувь	Тоо	Хувь	
1	10,000,000.0-аас дээш	3	143,217,906.99	61.1%	22,088	30.2%	
2	1,000,000.0 -10,000,000.0	18	54,503,350.74	23.3%	19,387	26.5%	
3	500,000.0-1,000,000.0	16	11,246,002.57	4.8%	5,803	7.9%	
4	100,000.0-500,000.0	86	18,259,647.68	7.8%	15,981	21.8%	
5	50,000.0-100,000.0	77	5,736,419.44	2.4%	7,460	10.2%	
6	10,000.0-50,000.0	41	1,284,108.67	0.5%	2,297	3.1%	
7	10,000.0 хүртэл	7	33,822.05	0.0%	167	0.2%	
Нийт дүн			248	234,281,258.14	100.0%	73,183	100.0%



3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд салбарын нийт зээлийн үлдэгдэл 171,180,118.27 мянган төгрөгт хүрч, нийт хөрөнгийн 73.1 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 166,264,967.94 мянган төгрөгт хүрч нийт хөрөнгийн 71.0 хувийг тус тус эзэлж байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 18 ХЗХ-ны зээлийн дүн салбарын нийт зээлийн 81.8 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тайлант улиралд 8 ХЗХ зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	18	140,044,456.22	81.8%
2	500,000.0-1,000,000.0	13	8,495,069.48	5.0%
3	100,000.0-500,000.0	73	15,744,338.08	9.2%
4	50,000.0-100,000.0	70	4,969,474.53	2.9%
5	10,000.0-50,000.0	58	1,881,593.10	1.1%
6	10,000.0 хүртэл	8	45,186.86	0.03%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	8	-	-
Нийт дүн		248	171,180,118.27	100%

3.4 Зээлийн чанарын талаар

2020 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны салбарын хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 92.9 хувь буюу 159,055,152.16 мянган төгрөгийг хэвийн зээл, 2.8 хувь буюу 4,847,300.82 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 4.3 хувь буюу 7,277,665.30 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 12,124,966.12 мянган төгрөгийн үлдэгдлийн 40.5 хувьд буюу 4,915,150.33 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 пунктээр өсөж 92.9 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 2.2 пунктээр буурч 2.8 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.5 пунктээр өсөж 4.3 хувьд хүрсэн байна.

График 8: Зээлийн чанар





График 9: Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР


4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар

Хүснэгт 12: ХЗХ-дын эх үүсвэрийн бүтэц (мянган төгрөгөөр)

ЭХ ҮҮСВЭР	2019 III улирал		2020 III улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Өр төлбөр	178,497,668.60	81.8%	186,806,165.93	79.7%	8,308,497.33	4.7%
Хадгаламж	154,420,879.30	70.7%	163,634,632.30	69.8%	9,213,753.00	6.0%
Хугацаагүй	2,352,944.70	1.1%	3,464,708.04	1.5%	1,111,763.34	47.2%
Хугацаатай	152,067,934.60	69.6%	160,169,924.26	68.4%	8,101,989.66	5.3%
Богино хугацаат зээл	4,807,437.50	2.2%	2,626,253.28	1.1%	-2,181,184.22	-45.4%
Бусад богино хугацаат өр төлбөр	13,659,093.40	6.3%	13,954,082.90	6.0%	294,989.50	2.2%
Урт хугацаат өр төлбөр	5,610,258.50	2.6%	6,591,197.46	2.8%	980,938.96	17.5%
Өөрийн хөрөнгө	39,859,224.70	18.2%	47,475,092.21	20.3%	7,615,867.51	19.1%
Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	17,531,534.90	8.0%	18,283,275.63	7.8%	751,740.73	4.3%
Гишүүний оруулсан хувь хөрөнгө	17,479,533.90	8.0%	18,040,921.91	7.7%	561,388.01	3.2%
Идэвхгүй гишүүний хувь хөрөнгө	52,001.10	0.0%	242,353.71	0.1%	190,352.61	366.1%
Дахин үнэлгээний нэмэгдэл	166,229.20	0.1%	156,460.05	0.1%	-9,769.15	-5.9%
Хоршоологчдын өмч	22,161,460.50	10.1%	29,035,356.53	12.4%	6,873,896.03	31.0%
Нөөцийн сан	4,271,699.60	2.0%	5,425,533.67	2.3%	1,153,834.07	27.0%
Хандив, тусламж	640,956.10	0.3%	515,031.12	0.2%	-125,924.98	-19.6%
Хадгаламж, хамгаалалтын сан	1,409,476.80	0.6%	1,860,845.64	0.8%	451,368.84	32.0%
Нийгмийн хөгжлийн сан	647,852.40	0.3%	770,136.50	0.3%	122,284.10	18.9%
Тогтворжилтын сан	1,402,150.60	0.6%	1,826,525.33	0.8%	424,374.73	30.3%
Бусад сангууд	1,063,866.30	0.5%	1,419,509.14	0.6%	355,642.84	33.4%
Хуримтлагдсан орлого /алдагдал/	12,725,458.70	5.8%	17,217,775.13	7.3%	4,492,316.43	35.3%
Тайлангийн үеийн цэвэр орлого	6,406,267.30	2.9%	7,439,454.50	3.2%	1,033,187.20	16.1%
Өмнөх үеийн цэвэр орлого	6,319,191.30	2.9%	9,778,320.64	4.2%	3,459,129.34	54.7%
Нийт өр төлбөр ба өөрийн Хөрөнгийн дүн	218,356,893.30	100%	234,281,258.14	100%	15,924,364.84	7.3%

Салбарын нийт өр төлбөр 186,806,165.93 мянган төгрөг нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7 хувь буюу 8,308,497.33 мянган төгрөгөөр, өөрийн хөрөнгө 47,475,092.21 мянган төгрөг нь 19.1 хувь буюу 7,615,867.51 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Эх үүсвэрийн бүтцийн 79.7 хувийг өр төлбөр, 20.3 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна.

График 10: Өр төлбөр болон өөрийн хөрөнгийн үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



ХЗХ-дын хоршоологчдын өмчийн хэмжээ 2016 оны 3 дугаар улиралд 11.0 тэрбум төгрөг байсан бол 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 164.0 хувь буюу 18.0 тэрбум төгрөгөөр өсөж 29.0 тэрбум төгрөгт хүрсэн. Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 2016 оны мөн үед 65.3 тэрбум төгрөг байсан бол 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 150.6 хувь буюу 98.3 тэрбум төгрөгөөр өсөж 163.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар


Салбарын татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 163,634,632.3 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 69.8 хувийг эзэлж байна. Нийт хадгаламжийн 97.9 хувийг хугацаатай хадгаламж, 2.1 хувийг хугацаагүй хадгаламж тус тус бүрдүүлж байна.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн дүнгээр 10 тэрбум төгрөгөөс дээш хадгаламжтай 3 ХЗХ-ны хадгаламж нийт ХЗХ-дын хадгаламжийн дүнгийн 65.7 хувийг эзэлж байна. Тайлант улиралд 13 ХЗХ хадгаламж татан төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт 13: ХЗХ-дын хадгаламж, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хадгаламжийн хэмжээ	ХЗХ-д	Хадгаламжийн дүн	Эзлэх хувь
1	10,000,000.0 дээш	3	107,554,024.93	65.7%
2	1,000,000.0-10,000,000.0	14	35,819,413.97	21.9%
3	500,000.0-1,000,000.0	7	4,812,812.49	2.9%
4	100,000.0-500,000.0	51	11,528,857.64	7.0%
5	50,000.0-100,000.0	21	1,549,110.88	0.9%
6	10,000.0-50,000.0	89	2,110,715.83	1.3%
7	5,000.0-10,000.0	23	185,603.92	0.1%
8	5,000.0 хүртэл	27	74,092.63	0.0%
9	Хадгаламжгүй	13	0	0.0%
Нийт дүн		248	163,634,632.30	100%

График 11: ХЗХ-ны салбарын хадгаламжийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/



Салбарын хэмжээнд нийт хадгаламжийн хэмжээ сүүлийн 5 жилийн хугацаанд жилд дунджаар 21.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар

Хүснэгт 14: ХЗХ-дын бусдаас авсан зээлийн бүтэц (мянган төгрөгөөр)

БУСДААС АВСАН ЗЭЭЛ	2019 Ш улирал		2020 Ш улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Богино хугацаат зээл	4,807,437.50	46.2%	2,626,253.28	28.5%	-2,181,184.22	-45.4%
Банкнаас авсан зээл	1,960,651.50	18.8%	199,023.59	2.2%	-1,761,627.91	-89.9%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	476,429.90	4.6%	749,513.36	8.1%	273,083.46	57.3%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	2,370,356.00	22.8%	1,677,716.34	18.2%	-692,639.66	-29.2%
Тогтворжилтын сангийн туслалцаа	-	0.0%	-	0.0%	-	-
Урт хугацаат өр төлбөр	5,610,258.50	53.8%	6,591,197.46	71.5%	980,938.96	17.5%
Банкнаас авсан зээл	3,554.20	0.0%	-	0.0%	-3,554.20	-100.0%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	211,373.50	2.0%	2,618,437.70	28.4%	2,407,064.20	1138.8%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	5,344,303.30	51.3%	3,952,677.69	42.9%	-1,391,625.61	-26.0%
Тогтворжилтын сангийн туслалцаа	-	0.0%	-	0.0%	-	-
Хойшлогдсон татварын өр төлбөр	51,027.50	0.5%	20,082.06	0.2%	-30,945.44	-60.6%
Нийт дүн	10,417,696.00	100.0%	9,217,450.73	100.0%	-1,200,245.27	11.5%

2020 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-дын бусдаас авсан зээлийн үлдэгдэл 9,217,450.73 мянган төгрөг нь салбарын нийт хөрөнгийн 3.9 хувийг эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.5 хувь буюу 1,200,245.27 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант улиралд бусдаас авсан нийт зээлийн 28.5 хувийг богино

хугацаат зээл, 71.5 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус бүрдүүлж байна. Богино хугацаат зээл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 45.4 хувь буюу 2,181,184.22

мянган төгрөгөөр буурч, урт хугацаат өр төлбөр 17.5 хувь буюу 980,938.96 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 15: ХЗХ-дын бусдаас авсан зээлийн бүтэц, хот, хөдөөгөөр /мянган төгрөгөөр/

БУСДААС АВСАН ЗЭЭЛ	Нийт		УБ		Орон нутаг	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Банкнаас авсан зээл	199,023.59	2.2%	133,273.09	1.5%	65,750.50	27.7%
Санхүүгийн байгууллагаас авсан зээл	3,367,951.06	36.6%	3,272,437.70	36.5%	95,513.36	40.3%
Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	5,630,394.03	61.2%	5,554,571.39	62.0%	75,822.64	32.0%
Нийт дүн	9,197,368.67	100.0%	8,960,282.17	100.0%	237,086.50	100.0%

ХЗХ-дын бусдаас авсан зээлийн хэмжээнд банкнаас авсан зээл 2.2 хувь, санхүүгийн байгууллагаас авсан зээл 36.6 хувь, төсөл, хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 61.2 хувийг тус тус эзэлж байна.

4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар

Хүснэгт 16: ХЗХ-дын бусад богино хугацаат өр төлбөрийн бүтэц /мянган төгрөгөөр/

БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2019 III улирал		2020 III улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Цалингийн өглөг	94,832.10	0.7%	135,904.39	1.0%	41,072.29	43.3%
Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг	982,842.10	7.2%	650,476.64	4.7%	-332,365.46	-33.8%
Ногдол ашгийн өглөг	933,138.00	6.8%	642,211.11	4.6%	-290,926.89	-31.2%
Санхүүгийн түрээсийн өглөг	652.5	0.0%	108.80	0.0%	-543.70	-83.3%
Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	89.1	0.0%	-	0.0%	-89.10	-100.0%
Урьдчилж орсон орлого	131,079.70	1.0%	70,576.67	0.5%	-60,503.03	-46.2%
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	10,502,462.80	76.9%	11,009,793.15	78.9%	507,330.35	4.8%
Салбар хоорондын тооцоогоорх өглөг	-	-	-	-	-	-
Бусад богино хугацаат өглөг	1,013,997.10	7.4%	1,445,012.13	10.4%	431,015.03	42.5%
Нийт дүн	13,659,093.40	100.0%	13,954,082.90	100.0%	294,989.50	2.2%

Тайлант улиралд ХЗХ-дын бусад богино хугацаат өр төлбөр 13,954,082.90 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 294,989.50 мянган төгрөг буюу 2.2 хувиар өссөн бөгөөд салбарын нийт хөрөнгийн 6.0 хувийг эзэлж байна.

4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар

Тайлант улиралд гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ 18,283,275.63 мянган төгрөг нь нийт эх үүсвэрийн 7.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 17: ХЗХ-дын гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо		Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн дүн	
			Дүн	Хувь	Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	2	20,967	28.7%	4,681,215.29	25.6%
2	500,000.0-1,000,000.0	5	3,392	4.6%	3,193,295.18	17.5%
3	100,000.0-500,000.0	29	20,308	27.7%	5,934,794.24	32.5%
4	50,000.0-100,000.0	21	5,851	8.0%	1,349,167.33	7.4%
5	10,000.0-50,000.0	107	16,546	22.6%	2,599,857.14	14.2%
6	5,000.0-10,000.0	63	5,028	6.9%	453,621.71	2.5%
7	5,000.0 хүртэл	21	1,091	1.5%	71,324.73	0.4%
	Нийт дүн	248	73,183	100%	18,283,275.63	100%

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгө 100 сая төгрөгөөс дээш 36 ХЗХ

Салбарын гишүүдийн оруулсан нийт хувь хөрөнгийн 75.6%

Нийт гишүүдийн 61.0%

4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

2020 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө 47,475,092.21 мянган төгрөгт хүрч, нийт эх үүсвэрийн 20.3 хувийг эзэлж байна.

Тайлант улиралд 13 ХЗХ-ны нийт өр төлбөрийн хэмжээ нь нийт хөрөнгөөс хэтэрсэн буюу өөрийн хөрөнгөгүй болсон байх бөгөөд тус ХЗХ-д нь “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан хоршоод байна.

Хүснэгт 18: ХЗХ-дын өөрийн хөрөнгийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Өөрийн хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	5	26,800,671.27	56.5%
2	500,000.0-1,000,000.0	11	7,507,550.80	15.8%
3	100,000.0-500,000.0	36	7,482,466.72	15.8%
4	50,000.0-100,000.0	44	3,046,135.93	6.4%
5	10,000.0-50,000.0	97	2,497,589.34	5.3%
6	10,000.0 доош	42	217,789.91	0.5%
7	Өөрийн хөрөнгөгүй	13	-77,111.77	-0.2%
Нийт дүн			248	47,475,092.21 100%

Хүснэгт 19: ХЗХ-дын хоршоологчдын өмч, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хоршоологчдын өмчийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	2	18,310,511.47	63.1%
2	500,000.0-1,000,000.0	3	2,317,341.79	8.0%
3	100,000.0-500,000.0	23	5,223,244.09	18.0%
4	50,000.0-100,000.0	20	1,424,827.28	4.9%
5	10,000.0-50,000.0	77	1,774,523.76	6.1%
6	5,000.0-10,000.0	25	186,338.27	0.6%
7	1,000.0-5,000.0	33	95,081.96	0.3%
8	1,000.0 хүртэл	15	7,227.00	0.0%
9	Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/	50	-303,739.08	-1.0%
Нийт дүн		248	29,035,356.53	100.0%

Тайлант улиралд 50 ХЗХ алдагдалтай ажилласны улмаас хоршоологчдын өмчгүй болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 ХЗХ буюу 20.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

5.1 ХЗХ-дын орлогын талаар

Тайлант улиралд салбарын нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.3 хувь буюу 1,990,282.21 мянган төгрөгөөр нэмэгдэж 39,307,035.21 мянган төгрөгт хүрсэн байна. Нийт орлогын 95.6 хувь хүүгийн орлого, 1.9 хувь үйл ажиллагааны

бусад орлого, 2.5 хувь үйл ажиллагааны бус орлого тус тус бүрдүүлж байна.

Зээлийн хүүгийн орлого 36,457,766.19 мянган төгрөгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.8 хувь буюу 2,330,743.19 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 20: ХЗХ-дын орлогын бүтэц (мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2019.ИИ		2020.ИИ		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1. Хүүгийн орлого	35,664,750.20	95.6%	37,596,710.81	95.6%	1,931,960.61	5.4%
Зээлийн хүүгийн орлого	34,127,023.00	91.5%	36,457,766.19	92.8%	2,330,743.19	6.8%
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	233,520.90	0.6%	191,353.97	0.5%	-42,166.93	-18.1%
Үнэт цаасны хүүгийн орлого	-	-	-	-	-	-
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого	1,485,331.50	4.0%	1,078,555.04	2.7%	-406,776.46	-27.4%
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого (Зээлийн хүүгийн орлогын буцаалт)	0	0.0%	16,997.24	0.0%	16,997.24	100.0%
	181,125.20	0.5%	147,961.63	0.4%	-33,163.57	-18.3%
2. Үйл ажиллагааны бусад орлого	736,159.10	2.0%	726,850.31	1.9%	-9,308.79	-1.3%
3. Үйл ажиллагааны бус орлого	915,843.70	2.4%	983,474.09	2.5%	67,630.39	7.4%
Нийт орлого	37,316,753.00	100.0%	39,307,035.21	100.0%	1,990,282.21	5.3%

5.2 ХЗХ-дын зардлын талаар

Салбарын нийт зардлын хэмжээ 31,867,580.72 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.1 хувь буюу 957,095.12 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт зардлын бүтцэд хүүгийн зардал 66.9 хувь, үйл ажиллагааны зардал 26.7 хувь, болзошгүй эрсдэлийн

сангийн зардал 4.0 хувь, 0.2 хувь үйл ажиллагааны бус зардал тус тус эзэлж байна. Хүүгийн зардал 21,321,961.46 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.3 хувь буюу 1,257,554.86 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 21: ХЗХ-дын зардлын бүтэц /мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2019.III		2020.III		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.Хүүгийн зардал	20,064,406.60	64.9%	21,321,961.46	66.9%	1,257,554.86	6.3%
Хадгаламжийн хүүгийн зардал	19,808,194.10	64.1%	20,948,451.42	65.7%	1,140,257.32	5.8%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	238,154.30	0.8%	356,255.20	1.1%	118,100.90	49.6%
Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	2,366.10	0.0%	0.00	0.0%	-2,366.10	-100.0%
Бусад хүүгийн зардал	39,885.70	0.1%	33,438.52	0.1%	-6,447.18	-16.2%
(Хүүгийн зардлын буцаалт)	24,193.60	0.1%	16,183.68	0.1%	-8,009.92	-33.1%
2. Болзошгүй эрсдэлийн сангийн зардал	1,706,069.40	5.5%	1,275,586.96	4.0%	-430,482.44	-25.2%
Зээлийн эрсдэлийн зардал	1,632,763.70	5.3%	1,405,105.25	4.4%	-227,658.45	-13.9%
Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	120,434.00	0.4%	14,151.75	0.1%	-106,282.25	-88.2%
(Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт)	47,128.20	0.2%	143,670.04	0.5%	96,541.84	204.8%
3. Үйл ажиллагааны зардал	8,289,601.50	26.9%	8,520,025.53	26.8%	230,424.03	2.8%
Боловсон хүчний зардал	5,524,187.00	17.9%	5,482,553.05	17.2%	-41,633.95	-0.8%
Бусад төрлийн зардал	2,765,414.50	9.0%	3,037,472.48	9.5%	272,057.98	9.8%
4. Үйл ажиллагааны бус зардал	231,283.20	0.7%	74,030.78	0.2%	-157,252.42	-68.0%
Татварын зардал	619,124.90	2.0%	675,975.98	2.1%	56,851.08	9.2%
Нийт зардал	30,910,485.60	100.0%	31,867,580.72	100.0%	957,095.12	3.1%
Цэвэр орлого	6,406,267.40	100.0%	7,439,454.50	100.0%	1,033,187.10	16.1%

5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар


2020 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны салбарын цэвэр орлого 7,439,454.50 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.1 хувь буюу 1,033,187.10 мянган төгрөгөөр өссөн байна.

Салбарын цэвэр орлого сүүлийн 5 жилийн 3 дугаар улирлын байдлаар тогтмол өссөн байна.

Зураг 6: Ашигт ажиллагааны зарим үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/



График 12: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/



5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-дын талаар

Хүснэгт 22: ХЗХ-дын цэвэр орлого, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Ашгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Ашгийн хэмжээ	Нийт ашигт эзлэх хувь	Хөрөнгийн хэмжээ	Хөрөнгийн өгөөж
1	100,000.0 дээш	9	6,085,084.41	76.9%	159,963,973.31	3.8%
2	50,000.0-100,000.0	9	683,220.78	8.6%	15,517,850.52	4.4%
3	10,000.0-50,000.0	37	846,582.32	10.7%	19,038,944.78	4.4%
4	5,000.0-10,000.0	21	146,496.05	1.9%	4,340,182.27	3.4%
5	1,000.0-5,000.0	48	125,223.34	1.6%	5,250,440.43	2.4%
6	1,000.0 хүртэл	50	23,090.78	0.3%	4,429,061.74	0.5%
Нийт дүн		174	7,909,697.68	100.0%	208,540,453.06	3.8%



2020 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 248 ХЗХ-ны 70.2 хувь буюу 174 ХЗХ 7,909,697.68 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. 100.0 сая төгрөгөөс дээш

ашигтай ажилласан 9 ХЗХ-ны ашиг салбарын нийт ашгийн 76.9 хувийг эзэлж байгаа бөгөөд хөрөнгийн өгөөж дунджаар 3.8 хувьтай байна.

5.5 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-дын талаар

2020 оны 3 дугаар улирлын байдлаар 248 ХЗХ-ны 25.4 хувь буюу 63 ХЗХ нь 470,243.19 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Алдагдалтай ажилласан ХЗХ-дын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11 ХЗХ буюу 14.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 23: ХЗХ-дын алдагдал, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Алдагдлын хэмжээ	ХЗХ-дын тоо	Алдагдлын хэмжээ	Нийт алдагдалд эзлэх хувь
1	10,000.0 дээш	9	-293,325.02	62.4%
2	5,000.0-10,000.0 хүртэл	15	-106,309.23	22.6%
3	1,000.0-5,000.0 хүртэл	24	-64,190.96	13.7%
4	1,000.0 хүртэл	15	-6,417.97	1.4%
Нийт дүн		63	-470,243.19	100.0%

Тайлант улиралд 10 сая төгрөгөөс дээш хэмжээний алдагдалтай ажилласан 9 ХЗХ-ны алдагдал 293,325.02 мянган төгрөг нь нийт алдагдлын 62.4 хувийг эзэлж байна.

ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ээр тогтоосон үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар

Хүснэгт 24: ХЗХ-дын шалгуур үзүүлэлт хангасан байдал

№	ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Хангаагүй ХЗХ-дын тоо	Хувь
Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт				
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу)	-97,131.40 мян.төг	46	18.5%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	39	15.7%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	40	16.1%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	2	0.8%
Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт				
1	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	60%-85%	100	40.3%

2	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	10	4.0%
3	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	20%-80%	73	29.4%
4	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	73	29.4%
5	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	6	2.4%
6	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%-аас доошгүй	85	34.3%
7	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	-	35	14.1%
8	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	36	14.5%
9	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	38	15.3%
Зардлын зохистой хэмжээ				
11	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	36	14.5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар				
12	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	5%-аас доошгүй	82	33.1%
Өгөөж, зардлын хувь хэмжээ				
13	Хөрөнгө /актив/-ийн өгөөж			3.2%

2020 оны 3 дугаар улирлын байдлаар нийт ХЗХ-дын 18.5 хувь буюу 46 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 91,131.40 мянган төгрөгөөр дутуу байгуулж ажилласан байна. Нийт ХЗХ-дын 15.7 хувь буюу 39 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцааг, 40.3 хувь буюу 100 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг, 29.4 хувь буюу 73 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа, бусдаас авсан зээлийн зохистой харьцааг, 34.3 хувь буюу 85 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцааг, 33.1 хувь буюу 82 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

ХЗХ-ны салбарын хөрөнгийн өгөөж 3.2 хувь байна.

Тайлант улиралд хангаж ажиллаагүй тохиолдолд Хорооноос тухайн ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч хэрэгжүүлэх хөрөнгө, эх үүсвэрийн 6 зохистой харьцааг ХЗХ-дын 27.8 хувь буюу 69 ХЗХ бүрэн хангаж ажилласан байна.

Хүснэгт 25: Эх үүсвэрийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	ХЗХ-дын тоо	Хувь
1	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	69	27.8%
2	1 ЗХШҮ хангаагүй	64	25.8%
3	2 ЗХШҮ хангаагүй	52	21.0%
4	3 ЗХШҮ хангаагүй	40	16.1%
5	4 ЗХШҮ хангаагүй	18	7.3%
6	5 ЗХШҮ хангаагүй	5	2.0%
Нийт дүн		248	100.0%

6.2 Улаанбаатар хотын ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар

Хүснэгт 26: Улаанбаатар хотын ХЗХ-дын шалгуур үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Хангаагүй ХЗХ-дын тоо	Хувь
Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт				
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу)	-45,636.88 мян.төг	30	20.0%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	30	20.0%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	38	25.3%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	2	1.3%
Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт				
1	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	60%-85%	55	36.7%
2	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	4	2.7%
3	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	20%-80%	56	37.3%
4	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	70	46.7%
5	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	5	3.3%
6	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%-аас доошгүй	71	47.3%

7	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	-	16	10.7%
8	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	17	11.3%
9	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	19	12.7%
Зардлын зохистой хэмжээ				
11	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	29	19.3%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар				
12	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	5%-аас доошгүй	54	36.0%
Өгөөж, зардлын хувь хэмжээ				
13	Хөрөнгө /актив/-ийн өгөөж			2.9%

2020 оны 3 дугаар улиралд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 150 ХЗХ-ны 20.0 хувь буюу 30 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 45,636.88 мянган төгрөгөөр дутуу байгуулж ажилласан байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын 20.0 хувь буюу 30 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцааг, 36.7 хувь буюу 55 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг, 37.3 хувь буюу 56 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцааг, 46.7 хувь

буюу 70 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцааг, 47.3 хувь буюу 71 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцааг, 36.0 хувь буюу 54 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа ХЗХ-дын хөрөнгийн өгөөж 2.9 хувь байна.

6.3 Орон нутгийн ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар

Хүснэгт 27: Орон нутгийн ХЗХ-дын шалгуур үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Хангаагүй ХЗХ-дын тоо	Хувь
Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт				
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу)	-51,494.52 мян.төг	16	16.3%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	9	9.2%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	2	2.0%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	0	0.0%
Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт				
1	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	60%-85%	45	45.9%
2	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	6	6.1%
3	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	20%-80%	17	17.3%
4	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	3	3.1%
5	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	1	1.0%
6	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%-аас доошгүй	14	14.3%
7	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	-	19	19.4%
8	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	19	19.4%
9	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	19	19.4%
Зардлын зохистой хэмжээ				
11	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	7	7.1%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар				
12	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	5%-аас доошгүй	28	28.6%
Өгөөж, зардлын хувь хэмжээ				
13	Хөрөнгө /актив/-ийн өгөөж			4.9%

Тайлант улиралд орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа 98 ХЗХ-ны 16.3 хувь буюу 16 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 51,494.52 мянган төгрөгөөр дутуу байгуулсан байна. Орон нутгийн ХЗХ-дын 9.2 хувь буюу 9 ХЗХ чанаргүй зээлийн зохистой харьцааг, 45.9 хувь буюу 45 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг, 17.3 хувь 17 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцааг, 3.1 хувь

буюу 3 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцааг, 14.3 хувь буюу 14 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцааг, 28.6 хувь буюу 28 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа ХЗХ-дын хөрөнгийн өгөөж 4.9 хувь байна.

6.4 “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар

Хүснэгт 28: Нийслэлийн төслийн ХЗХ-дын шалгуур үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Хангаагүй ХЗХ-дын тоо	Хувь
Хөрөнгийн чанар болон хамгаалалтын үзүүлэлт				
1	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ илүү, -дутуу)	-39,854.18 мян.төг	21	25.3%
2	Чанаргүй зээлийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	16	19.3%
3	Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	32	38.6%
4	Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	2	2.4%
Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт				
1	Нийт хөрөнгө /актив/-д эзлэх зээлийн зохистой харьцаа	60%-85%	35	42.2%
2	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	2	2.4%
3	Гишүүдийн хадгаламжийн зохистой харьцаа	20%-80%	42	50.6%
4	Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	68	81.9%
5	Нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	1	1.2%
6	Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%-аас доошгүй	50	60.2%
7	Нөөцийн сангийн байвал зохих доод хэмжээ	-	9	10.8%
8	Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	10	12.0%
9	Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ	-	12	14.5%
Зардлын зохистой хэмжээ				
11	Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	22	26.5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар				
12	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	5%-аас доошгүй	40	48.2%
Өгөөж, зардлын хувь хэмжээ				
13	Хөрөнгө /актив/-ийн өгөөж			0.01%

2020 оны 3 дугаар улиралд “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан 83 ХЗХ-ны 25.3 хувь буюу 21 ХЗХ зээлийн эрсдэлийн санг 39,854.18 мянган төгрөгөөр дутуу байгуулсан байна. Төслийн ХЗХ-дын 48.2 хувь буюу 40 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа, 20.5 хувь буюу 17 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцааг, 81.9 хувь

буюу 68 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцааг, 16.9 хувь буюу 14 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцааг, 41.0 хувь буюу 34 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна.

Тус ХЗХ-дын хөрөнгийн өгөөж 0.01 хувь байна.

Санхүүгийн тайлангийн нэгтгэлд нийт 248 ХЗХ хамрагдсанаас 19 ХЗХ өмнөх улирлын тайлангаар, 5 ХЗХ эхлэлтийн тайлангаар нэгтгэсэн болно.

- ХЗХ-дын статистик үзүүлэлт

2020 оны 3 дугаар улирлын байдлаар 248 ХЗХ 61 салбар, 805 ажилтантай, 73,183 гишүүнтэй /73,044 иргэн, 139 хуулийн этгээд/ Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулсан байна.

ХЗХ-дын эрхэлж буй санхүүгийн бусад ажил үйлчилгээг авч үзвэл тайлант хугацаанд 37.1 хувь буюу 92 ХЗХ төслийн санхүүжилтийг дамжуулан хэрэгжүүлэх, 1.2 хувь буюу 3 ХЗХ санхүүгийн түрээсийн үйлчилгээ, 1.6 хувь буюу 4 ХЗХ даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байна. Төслийн санхүүжилтийг дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөлтэй 92 ХЗХ-ны 90.2 хувь буюу 83 ХЗХ “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-д байна.

Тайлант хугацаанд ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үеэс 4.4 хувь буюу 3,062 гишүүнээр нэмэгдэж 73,183 гишүүнтэй болсон байна. Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн тоо 44,902 буюу нийт гишүүдийн 61.4 хувь, орон нутгийн ХЗХ-дын гишүүдийн тоо 28,281 буюу нийт гишүүдийн 38.6 хувийг эзэлж байна.

Нийт ХЗХ-дын 29 хувь буюу 72 ХЗХ санхүүгийн програм хангамжтай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 ХЗХ буюу 1.2 хувиар буурсан нь 15 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой хамааралтай юм.

- Салбарын санхүүгийн үзүүлэлт

Салбарын нийт хөрөнгө 234,281,258.14 мянган төгрөг нь банкны салбарын 0.7 хувь, нийт зээл 171,180,118.27 мянган төгрөг нь

банкны салбарын 1.0 хувь, чанаргүй зээл 7,227,665.30 мянган төгрөг нь банкны салбарын 0.4 хувь, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 163,634,632.30 мянган төгрөг нь банкны салбарын 1.0 хувийг тус тус эзэлж байна.

ХЗХ-дын нийт хувь хөрөнгө 18,283,275.63 мянган төгрөг нь салбарын нийт хөрөнгийн 7.8 хувь, хоршоологчдын өмч 29,035,356.53 мянган төгрөг нь салбарын нийт хөрөнгийн 12.4 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд 39,307,035.21 мянган төгрөгийн орлого, 31,867,580.72 мянган төгрөгийн зардал, 7,439,454.50 мянган төгрөгийн цэвэр орлоготой ажилласан байна. Цэвэр орлогын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 16.1 хувь буюу 1,033,187.10 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Салбарын хэмжээнд “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын нийт хөрөнгө 8,181,088.23 мянган төгрөг буюу 3.5 хувь, нийт зээл 6,644,824.32 мянган төгрөг буюу 3.9 хувь, чанаргүй зээл 299,647.52 мянган төгрөг буюу 4.1 хувь, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 2,030,408.56 мянган төгрөг буюу 1.2 хувийг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд тус ХЗХ-д 1,113,828.02 мянган төгрөгийн орлого, 1,113,300.55 мянган төгрөгийн зардал, 527.47 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Харин “Ногоон алт” төслийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын хувьд салбарын хэмжээнд нийт хөрөнгө 7,769,013.72 мянган төгрөг буюу 3.3 хувь, нийт зээл 6,559,185.34 мянган төгрөг буюу 3.8 хувь, чанаргүй зээл 160,845.16 мянган төгрөг буюу 2.2 хувь, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 5,132,809.96 мянган төгрөг буюу 3.1 хувийг тус тус эзэлж байна. Тайлант улиралд уг төслийн хүрээнд байгуулагдсан 31 ХЗХ 1,448,072.34 мянган төгрөгийн орлого, 1,125,852.93 мянган

төгрөгийн зардал, 322,219.41 мянган төгрөгийн цэвэр орлоготой ажилласан байна.

- Хөрөнгийн бүтэц, зээлийн үйл ажиллагаа

Тайлант улиралд цэвэр зээлийн үлдэгдэл 166,264,967.94 мянган төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 71.0 хувийг бүрдүүлж байна.

ХЗХ-ны салбарын нийт хөрөнгөд хэвийн зээлийн үлдэгдэл 159,055,152.16 мянган төгрөг нь 67.9 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 4,487,300.82 мянган төгрөг нь 2.1 хувь, чанаргүй зээлийн үлдэгдэл 7,277,665.30 мянган төгрөг нь 3.1 хувийг тус тус эзэлж байна. ХЗХ-ны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,090,845.90 мянган төгрөг буюу 17.6 хувь өссөн үзүүлэлттэй байна.

- Өр төлбөр ба өөрийн хөрөнгө

ХЗХ-дын нийт өр төлбөр болон өөрийн хөрөнгийн 69.8 хувь буюу 163,634,632.30 мянган төгрөгийг хадгаламж, 9.9 хувь буюу 23,171,533.64 мянган төгрөгийг урт, богино хугацаат өр төлбөр, 7.8 хувь буюу 18,283,275.63 мянган төгрөгийг гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, 12.4 хувь буюу 29,035,356.53 мянган төгрөгийг хоршоологчдын өмч тус тус бүрдүүлж байна.

ХЗХ-дын гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн 97.9 хувь буюу 160,169,924.26 мянган төгрөгийг хугацаатай хадгаламж, 2.1 хувь буюу 3,464,708.04 мянган төгрөгийг хугацаагүй хадгаламж эзэлж байна.

- Орлого, зарлага

Тайлант хугацаанд ХЗХ-ны салбарын нийт орлогын 95.6 хувь буюу 97,596,710.81 мянган төгрөгийг хүүгийн орлого, 1.8 хувь буюу 726,850.31 мянган төгрөгийг үйл ажиллагааны бусад орлого, 2.5 хувь буюу 983,474.09 мянган төгрөгийг үйл

ажиллагааны бус орлого, нийт зардлын 66.9 хувь буюу 21,321,961.46 мянган төгрөгийг хүүгийн зардал, 26.7 хувь буюу 8,520,025.53 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардал тус тус бүрдүүлж байна. Салбарын хэмжээнд цэвэр орлого 7,439,454.50 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.1 хувь буюу 1,033,187.20 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт боловч ХЗХ-дын 25.4 хувь буюу 63 ХЗХ 470,243.19 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

- Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд Хорооноос тогтоосон зайлшгүй хангах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ХЗХ-дын 27.8 хувь буюу 69 ХЗХ бүрэн хангаж ажилласан бөгөөд 40.3 хувь буюу 100 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг, 29.4 хувь буюу 73 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцааг, 34.3 хувь буюу 85 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцааг, 33.1 хувь буюу 82 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна. ХЗХ-ны салбарын хөрөнгийн өгөөж 3.2 хувь байна.

“Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан ХЗХ-дын 42.2 хувь буюу 35 ХЗХ нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааг, 50.6 хувь буюу 42 ХЗХ гишүүдийн хадгаламжийн зохистой харьцааг, 81.9 хувь буюу 68 ХЗХ бусдаас авсан зээлийн зохистой харьцааг, 48.2 хувь буюу 40 ХЗХ төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг, 60.2 хувь буюу 50 ХЗХ хоршоологчдын өмчийн зохистой харьцааг тус тус хангаж ажиллаагүй байна. Тус ХЗХ-дын хөрөнгийн өгөөж 0.01 хувьтай байна.